



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 411

Улаанбаатар хот

"Чингэлтэйн түншлэл" ХЗХ-нд тусгай зөвшөөрөл олгох,  
төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.4, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 82 дугаар тогтоолоор батлагдсан "Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний жагсаалт"-ын 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Чингэлтэйн түншлэл" ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгож, төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг "Чингэлтэйн түншлэл" ХЗХ /П.Ганзориг/-нд үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000092